



БАТЛАВ:.....Б.ОЧИРХУЯГ

МУИС-ИЙН ЗАХИРДЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



**МУИС-ИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН
ГАЗАРЗҮЙ, ГЕОЛОГИЙН ЛАБОРАТОРИЙН ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт/гэрээний нэр: ШУС-ийн лабораторийн тоног төхөөрөмж

Дугаар:

МУИС/201902003

УЛААНБААТАР
2020 ОН



Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Монгол улсын их сургууль нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн “Газарзүй, Геологийн лабораторийн тоног төхөөрөмж” нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул Тендерт оролцогч нь цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д өөрийн аж ахуйн нэгжийн үндэсний тоон гарын үсгийн гэрчилгээг ашиглан хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим /PDF/ хэлбэрээр 2020 оны 07 дүгээр сарын 02 -ны өдрийн 11 цагаас өмнө ирүүлнэ.

Үнийн саналыг 2020 оны 07 дугаар сарын сарын 02-ны өдрийн 11 цаг 20 минутад нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй барааны давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Захиалагчийн хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж, МУИС-ийн хичээлийн №1 байр, 215 тоот,
Эдийн засагч, Утас: **9595-2535, 77307730 - 1180**



Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болно нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
 - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**



ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none">1. <i>Үнийн санал ирүүлэх маягтыг бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ,</i>2. <i>Үнийн санал ирүүлэхдээ тендерийн баримт бичигт байгаа барааны техникийн тодорхойлолтод заасан шаардлагатай харьцуулсан байдлаар хүснэгтээр ирүүлнэ.</i>3. <i>Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ,</i>4. <i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтыг ирүүлнэ,</i>5. <i>Байгууллагын гэрчилгээний хуулбар хувь</i>6. <i>Татварын ерөнхий газрын www.etax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь, тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй, өргүй байна.</i>7. <i>Харилцагч банкны тодорхойлолт</i>8. <i>Нийлүүлэх барааны зураг, танилцуулгын хамт ирүүлэх,</i>9. <i>Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ,</i>10. <i>Тендерийн баримт бичгийн 5, 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ,</i>11. <i>2018, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан (Тендерийн материалд ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээс шалгана)</i>12. <i>2019 оны аудитлагдсан санхүүгийн тайланг PDF хэлбэрт хөрвүүлж ирүүлнэ.</i>13. <i>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил (2018, 2019)</i>14. <i>Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнтэй тэнцүү, түүнээс багагүй байна.</i>15. <i>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ санал болгож буй үнийн дүнгийн 50%-иас багагүй байна. /Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 343 дугаар Аргачлал шинэчлэн батлах тухай аргачлалын дагуу тооцно./ - Арилжааны банкны зээл авч болох мөнгөн дүн бүхий батлагдсан зээлийн тодорхойлолт ирүүлнэ. /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой гэсэн мэдэгдлийг үнэлгээнд харгалзахгүй/.</i> <p><i>Жич: ТШӨХ-д заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. /2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 11 цагаас өмнө ирүүлнэ/</p>



ТӨӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Ү Байшин, гудамжны нэр: МУИС хичээлийн №1 байр, Их сургуулийн гудамж Давхар болон өрөөний дугаар: 2 давхар, 215 тоот Аймаг, хот: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг Улс: Монгол Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Цаг: 11 цаг 20 минутад
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багцтай</i>



Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

- 1. Барааны тодорхойлолт:** Барааны тодорхойлолт, техникийн үзүүлэлт доор бичсэнтэй адил байна
- 2. Стандарт:** Лабораторийн тоног төхөөрөмжийн шаардлагыг хангана.
- 3. Баглаа, боодол:** Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тунадас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна. Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ гэрээнд, нэн ялангуяа гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.
- 4. Бараа хүргэх газар:** Монгол улс, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, Бага тойруу, Их сургуулийн гудамж, МУИС-ийн хичээлийн 1-р байр, 2-р байр. Холбоо барих утас: 96054799, 80700880
- 5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо шир хэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Багц 1. Геологийн багаж, тоног төхөөрөмж							
<i>Микроскоп</i>	<i>Тодорхойлолтод зааснаар</i>	<i>1</i>	<i>ш</i>	<i>МУИС, ШУС ХБ-2</i>	<i>Гэрээ байгуулснаас хойш 3 хоног</i>	<i>Гэрээ байгуулснаас хойш 80 хоног</i>	
Багц 2. Газарзүйн лабораторийн багаж, тоног төхөөрөмж							
<i>Дрон</i>	<i>Тодорхойлолтод зааснаар</i>	<i>1</i>	<i>ш</i>	<i>МУИС, ШУС ХБ-2</i>	<i>Гэрээ байгуулснаас хойш 3 хоног</i>	<i>Гэрээ байгуулснаас хойш 30 хоног</i>	
<i>Автомат нивилер</i>	<i>Тодорхойлолтод зааснаар</i>	<i>2</i>	<i>ш</i>	<i>МУИС, ШУС ХБ-2</i>	<i>Гэрээ байгуулснаас хойш 3 хоног</i>	<i>Гэрээ байгуулснаас хойш 30 хоног</i>	
<i>Электрон теодолит</i>	<i>Тодорхойлолтод зааснаар</i>	<i>2</i>	<i>ш</i>	<i>МУИС, ШУС ХБ-2</i>	<i>Гэрээ байгуулснаас хойш 3 хоног</i>	<i>Гэрээ байгуулснаас хойш 30 хоног</i>	



Техникийн тодорхойлолт
Багц 1. Геологийн багаж, тоног төхөөрөмж

№	Барааны нэр, төрөл	Техникийн үзүүлэлт	Тоо хэмжээ
1	Нэвтэрсэн ба ойсон гэрлийн туйлширсан <u>микроскоп</u>	<p>Нэвтэрсэн ба ойсон гэрлийн туйлширсан микроскоп (Polarized Transmitted and Reflected Light Microscope)</p> <ol style="list-style-type: none">1. Марк: Motic /BA 310 POL+EPI/ дүйцэхүйц2. Их биеийн дээд хэсэг нь Окуляр ба фотоаппарат суурилуулах оптикийн CCIS системтэй байна3. Окулярууд N-WF10x/20 (Нэг нь кресттэй, нэг нь микрометрийн хэмжээстэй)4. Анализатор, полиризатортой байна5. ¼ долгионы урттай кварцын шаантагтай байна (I-IV).6. Бертраны линзтэй байна7. Объектив суурилуулах 4 нүхтэй, төвлөрүүлэгчийн оролттой, тохируулгатай конвертертэй байна.8. Объективууд: 4x, 10x, 20x, 40x9. 360 градусын эргэлттэй тавцантай байна.10. Туйлшруулагч: 360 градусын эргэлттэй тавцантай байна.11. Цуглуулагч линз: N.A 0.9/0.13 ба түүнээс дээш үзүүлэлттэй байна.12. 6A/30W ба түүнээс дээш үзүүлэлттэй галлоген тохируулгатай чийдэн суурилуулах гэртэй байна.13. Гүйдлийн трансформатор: 200 мА, Чадал: 1,0 В ба түүнээс дээш14. Motic микро фото аппарат: нарийвчлал 2048x1536 ба түүнээс дээш, хэмжээ 3.2x3.2 микрометрийн хэмжээтэй 3,100,000 ба түүнээс дээш нягтралтай15. Программ хангамж: График хэмжилт хийх боломжтой, автомат гэрэлтүүлэгтэй, зурган боловсруулалт, фото зураг авах боломжтой байна.16. 0.65 x ба түүнээс дээш үзүүлэлттэй Фото аппаратын адаптортой байна17. Ойсон гэрлийн иллюминатор системтэй байх (EPI)18. Иммерсийн шингэнтэй ажиллах 60^X ийн объектив19. Шлифийн зузаан хэмжигч багаж (Mitutoyo scale 0-25 mm)	1 иж бүрдэл



Нэвтэрсэн ба
ойсон гэрлийн
туйлширсан
микроскоп

**Motic BA 310
POL+EPI**

Зураг





Багц 2. Газарзүйн лабораторийн багаж, тоног төхөөрөмж

№	Барааны нэр, төрөл	Техникийн үзүүлэлт	Тоо хэмжээ
2	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж /Дрон/	<ul style="list-style-type: none"> ✓ Марк: <u>Phantom 4 Pro V2.0 SPECS</u> дүйцэхүйц ба түүнээс дээш үзүүлэлт бүхий ✓ Зориулалт Газарзүйн тэнхим-/Тоон фотограмметр болон GEOI208 Агаар сансрын тоон мэдээг боловсруулах хичээлүүдэд/ ✓ Жин (баттерейны хамт): 1375 g ✓ Диангаль хэмжээ (Сэнс оруулахгүйгээр): 350 mm ✓ Өгсөх Дээд хурд S-mode: 6 m/s, P-mode: 5 m/s ✓ Уруудах дээд хурд S-mode: 4 m/s, P-mode: 3 m/s ✓ Дээд хурд S-mode: 45 mph (72 kph), A-mode: 36 mph (58 kph), P-mode: 31 mph (50 kph) ✓ Хазайх дээд хурд S-mode: 42°, A-mode:35°, P-mode: 25° ✓ Өнцгөн дээд хурд S-mode: 250°/s, A-mode: 150°/s ✓ Зураглах далайн түвшинээс дээш хамгийн их өндөр 19685 feet (6000 m) ✓ Салхинд тогтох дээд хурд 10 m/s ✓ Агаарт байх нислэгийн дээд хугацаа ойролцоогоор 30 minutes ✓ Ажиллах температур 32° to 104°F (0° to 40°C) ✓ Хиймэл дагуулын байршил тогтоох систем GPS/GLONASS ✓ Байршлын Нарийвчлалын Босоо:±0.1 m (харагдах байршлаар),±0.5 m (GPS-ээр) Хэвтээ: ±0.3 m (харагдах байршлаар) ±1.5 m (GPS-ээр) ✓ Харах систем: Урагш хараалах систем, арагшаа хараалах систем, доошоо хараалах систем ✓ Хурдны хязгаар газраас: 2 m өндөрт 31 км/ц (50 км/ц) -аас бага буюу ✓ Өндрийн хязгаар: 0 - 10 m ✓ Үйлдлийн хязгаар: 0 - 10 m ✓ Саад мэдрэх хязгаар: 0.7 - 30 m ✓ Харагдах талбай: Урагш-60°(Хэвтээ), ±27°(Босоо) Арагш - 60°(Хэвтээ), ±27°(Босоо) Доош: 70°(урагшаа, арагшаа), 50°(зүүн баруун) ✓ Хэмжих хэлбэлзэл: Урагш: 10 Hz Арагш: 10 Hz Доош: 20 Hz ✓ Ажиллах орчин: Хангалттай гэрэлтүүлэгтэй талбай (lux>15) ✓ Мэдрэгч: 1'' CMOS ✓ Нягтрал: 20M ✓ Линц FOV 84° 8.8 mm/24 mm (35 mm форматтай тэнцэнэ) f/2.8 - f/11 авто фокус 1 m - ∞ ✓ ISO хязгаар Видео: 100 - 3200 (Автомат) 100 - 6400 (Гар) ✓ Зураг:100 - 3200 (Автомат), 100- 12800 (Гар) ✓ Механик хөшигний хурд 8 - 1/2000 s ✓ Электрон хөшигний хурд 8 - 1/8000 s ✓ Зургийн хэмжээ: 3:2 ✓ Чиглэлийн харьцаа: 5472 × 3648 4:3 Чиглэлийн харьцаа: 4864 × 3648 16:9 Чиглэлийн харьцаа: 5472 × 3078 ✓ PIV зургийн хэмжээ 4096×2160 (4096×2160 24/25/30/48/50p) 	1 ш



		<p>3840×2160(3840×2160 24/25/30/48/50/60p) 2720×1530(2720×1530 24/25/30/48/50/60p) 1920×1080(1920×1080 24/25/30/48/50/60/120p) 1280×720(1280×720 24/25/30/48/50/60/120p)</p> <ul style="list-style-type: none">✓ Фотозургийн формат: Нэг удаагийн авалт✓ Дараалал авалт: 3/5/7/10/14 frames✓ Автомат авалт (АЕВ): 3/5 хаалтын хүрээ at 0.7 EV Bias✓ Интервал: 2/3/5/7/10/15/20/30/60 s✓ Видео авах дээд хурд: 100 Mbps✓ Дэмждэг файлын систем FAT32 (≤32 GB); exFAT (>32 GB)✓ Фото: JPEG, DNG (RAW), JPEG + DNG✓ Видео: MP4/MOV (AVC/H.264; HEVC/H.265)✓ Дэмждэг: SD кард Мидро SD✓ Багтаамж: 128GB✓ Бичих хурд ≥15MB/s, Ангилал 10 эсвэл UHS-1 зэрэглэл✓ Ажиллах температурын хязгаар 0° to 40°C✓ Цэнэглэгч Вольт: 17.4 V✓ Цэнэглэгч Чадал: 100 W✓ Зөөврийн программ: DJI GO 4✓ Шууд ажиллах давтамж: 2.4 GHz ISM, 5.8 GHz ISM✓ Шууд ажиглалт хийх чанар: 720P @ 30fps, 1080P @ 30fps✓ Нислэгийн хугацаа: Phantom 4 Pro + V2.0 : 160 - 180 ms, Тогтворжуулагч 3-гэнхлэгийн дагуу , Хяналтын хязгаар босоо: -90° -аас +30°✓ Хянагдах хамгийн их хурд босоо: 90°/s✓ Чичиргээний өнцгөн хязгаар: ±0.02°✓ Ойролцоо мэдрэгчийн хязгаар: 0.6 - 23 feet (0.2 - 7 m)✓ FOV 70° (Horizontal), ±10° (Vertical)✓ Хэмжилтийн хэлбэлзэл: 10 Hz✓ Ажиллах орчин Диффуц ойлт бүхий гадарга > 8% (хана, мод, хүн... г.м.)✓ Ажлын давтамж 2.400 - 2.483 GHz and 5.725 - 5.850 GHz✓ Хамгийн их мэдээлэл дамжуулах зай 2.400 - 2.483 GHz (саадгүй, нээлттэй орчинд)✓ FCC: 4.3 mi (7 km)✓ CE: 2.5 mi (4 km)✓ SRRC: 2.5 mi (4 km)✓ 5.725 - 5.850 GHz (саадгүй, нээлттэй орчинд)✓ FCC: 4.3 mi (7 km)✓ CE: 1.2 mi (2 km)✓ SRRC: 3.1 mi (5 km)✓ Ажиллах температур 0° to 40°C✓ Баттерей: 6000 mAh LiPo 2S✓ Дамжуулагчийн чадал (EIRP): 2.400 - 2.483 GHz✓ FCC: 26 dBm✓ CE: 20 dBm✓ SRRC: 20 dBm✓ MIC: 17 dBm✓ 5.725 - 5.850 GHz✓ FCC: 26 dBm✓ CE: 14 dBm✓ SRRC: 20 dBm✓ Ажиллах чадал, вольт 1.2 A@7.4 V✓ Видео гаралтын порт GL300K: HDMI✓ GL300L: USB✓ Мобайл төхөөрөмжийн суурь GL300K: суурилуулсан төхөөрөмж (5.5 inch дэлгэц, 1920×1080, 1000 cd/m2, Android үйлдлийн систем, 4 GB RAM+ 16 GB ROM)✓ GL300L: Таблет болон ухаалаг утас	
--	--	--	--



		<ul style="list-style-type: none"> ✓ Багтаамж: 5870 mAh ✓ Вольт: 15.2 V ✓ Батерейны төрөл: LiPo 4S ✓ Чадал: 89.2 Wh ✓ Жин: 468 g ✓ Цэнэглэх температур: 41° to 104°F (5° to 40°C) ✓ Цэнэглэх хамгийн их чадал: 160 W 	
	Зураг		

№	Барааны нэр, төрөл	Техникийн үзүүлэлт	Тоо ХЭМЖЭЭ	Зураг
3	Автомат нивелир	<ul style="list-style-type: none"> ✓ Марк: <u>Торсон АТ-В4-тэй дүйцэхүйц ба түүнээс дээш үзүүлэлт бүхий</u> ✓ Зориулалт Газарзүй тэнхим /Геодез-1,2,3 хичээлүүдэд/ ✓ Үйлдвэрлэсэн улс: Япон ✓ Нарийвчлал ±2мм ✓ Дурангийн өсгөх чадал: 24x ✓ Дурангийн таталт: 0.3м ✓ Ажиглалтын температур (-20°C+50°C) ✓ Дагалдах зүйл: Хөл, Рейк 5м ✓ Баталгаа: 1 жил 	2 ш	
4	Электрон теодолит	<ul style="list-style-type: none"> ✓ Марк: <u>Kolida kt-02/05-тай дүйцэхүйц ба түүнээс дээш үзүүлэлт бүхий</u> ✓ Зориулалт Газарзүйн тэнхим /Геодез-1,2,3 хичээлүүдэд/ ✓ Үйлдвэрлэсэн улс БНХАУ ✓ Нарийвчлал: ±2мм ✓ Дурангийн өсгөх чадал: 30x ✓ Дурангийн таталт: 0.8м ✓ Ажиглалтын температур: (-20°C+50°C) ✓ Чадал: Хэвтээ болон босоо өнцөг хэмжинэ ✓ Дагалдах зүйл: Хөл ✓ Баталгаа: 1 жил 	2 ш	



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |



Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)** 1.1. Барааг мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн комисс хүлээн авах ба шаардлагатай бол үйл ажиллагааны туршилтуудыг хийнэ. Барааг угсарч, суурилуулж, тохируулга, сургалт хийж хүлээлгэн өгнө.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** 5.1. Баталгаат засвар шаардлагатай.
1 жил байна.
- 4. Төлбөр (ГЕН-7)** 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Барааг хүлээн авахад төлөх төлбөр:** Барааг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор гэрээний нийт үнийн дүнтэй тэнцэх дүнг нэхэмжлэх болон захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН-9)¹** 9.1. Алданги оногдуулах хувь: *Хугацаа хоцорсон хоног бүр 0,1%-ийн алданги тооцно.*
- Алдангийн нийт дүн: *10%-иас хэтрэхгүй байна.*

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.



Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).
Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.
³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.



Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]